

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төслийн нэр	3
1.2 Төсөл хэрэгжүүлэгч	3
1.3 Төслийн гол зорилго	3
1.4 Төслийн цар хүрээ.....	3
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	4
2.1 Төслийн талбайн байршил	4
2.2 Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн уур амьсгалын нөхцөл.....	5
2.2.1 Агаарын температур ба дулааны горим	5
2.2.2 Хур тунадас	7
2.2.3 Салхины горим.....	8
2.2.4 Хөрсний температур	9
2.2.5 Гадаргын болон газар доорх ус.....	10
2.2.5.1 Бүс нутгийн гадаргын усны чанар	10
2.2.6 Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн судалгаа	12
2.2.6 Нутаг дэвсгэрийн хөрсний тархалт	15
2.2.7 Ургамалан нөмрөг болон ойн бүрхэвч	15
2.2.8 Хээрийн судалгааны бичиглэл.....	15
2.2.9 Амьтны аймгийн төлөв байдал	16
2.2.10 Нийгэм-эдийн засгийн төлөв байдал.....	17
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	18
3.1 Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ.....	18
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	20
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ..	26
НАЙМ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	28
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	32
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	33
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	37
АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-НИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	38
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	40

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт- 1. Хатгал станцын агаарын температурын дундаж, үнэмлэхүйн их, бага утга (°C)*	6
Хүснэгт- 2. Хур тунадасны жилийн доторх өөрчлөлт	7
Хүснэгт- 3. Хөвсгөл нуурын усны химийн шинжилгээний тодорхойлолт	11
Хүснэгт- 4. Хатгал тосгоны худгийн усны шинжилгээний тодорхойлолт	11
Хүснэгт- 5. Хөрсний дээж авсан цэгийн байршил	12
Хүснэгт- 6. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим	18
Хүснэгт- 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	21
Хүснэгт- 8. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө	25
Хүснэгт- 9. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	27
Хүснэгт- 10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	28
Хүснэгт- 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	32
Хүснэгт- 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	33
Хүснэгт- 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	37
Хүснэгт- 14. БОМТ-ний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө	38
Хүснэгт- 15. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	39

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг- 1.Төсөл хэрэгжих байршлуудыг засаг захиргааны хуваарийн зурагт үзүүлэв.....	4
Зураг- 2. Төсөл хэрэгжих бүс нутгийн байгалийн бүс бүслүүрийн зураг	5
Зураг- 3. Хөвсгөл аймгийн 1 ба 7 дугаар сарын дундаж агаарын температурын тархалт	6
Зураг- 4. Агаарын температурын олон жилийн явц	6
Зураг- 5. Хөвсгөл аймгийн жилийн нийлбэр хур тунадасны тархалт	7
Зураг- 6. Жилийн нийлбэр хур тунадасны олон жилийн явц.....	8
Зураг- 7. Салхины зүгийн давтагдал.....	8
Зураг- 8. Салхины сарын дундаж болон хамгийн их хурд, м/с.....	8
Зураг- 9. Хатгал станц дахь хөрсний температурын үзүүлэлтүүд.....	9
Зураг- 10. Хөрсний гадаргын температурын олон жилийн явц	9
Зураг- 11. Гадаргын усны сүлжээ	10
Зураг- 12. Хөрсний дээж авсан цэгүүдийн байршил	13
Зураг- 13.Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хөрсний тархалтын зураг	14
Зураг- 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн цэгүүдийн байршил	36

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

“Хатуу хучилттай автозам, авто зогсоол, явган жим, нэвтрэх цэгүүд байгуулах төсөл”

1.2 Төсөл хэрэгжүүлэгч

“Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл (МОН3787/3788)”-ийн “Хөвсгөл дэд төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгж

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот
Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп плаза 601 тоот
Утас: 99021937, 91915139

1.3 Төслийн гол зорилго

Тухайн төслийн гол зорилго нь Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын бүсэд тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбараас нуурын хүрээлэн буй орчны экосистемд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, аялал жуулчлалд зориулсан хатуу хучилттай автозам болон дэд бүтцийг байгуулах ажил болно.

1.4 Төслийн цар хүрээ

Азийн хөгжлийн банкнаас Монгол улсад хэрэгжүүлж буй “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл (МОН3787/3788)”-ийн “Хөвсгөл дэд төсөл”-ийн хүрээнд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт хатуу хучилттай автозам ба авто зогсоолууд, явган аяллын жим, аялал жуулчлалын бүсийн нэвтрэх цэгүүд болон ариун цэврийн байгууламжууд байгуулах, мөн Ханх сумын нутаг дэвсгэрт нэвтрэх цэг болон ариун цэврийн байгууламж байгуулах төслийг тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тухайн төсөл хэрэгжих бүс нутаг буюу Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газар (ХНБЦГ) нь Алаг-Эрдэнэ, Ханх, Ренчинлхүмбэ, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр нутаг дэвсгэрийн хэсгүүдээс бүрддэг. ХНБЦГ-ын бүсэд 2 үндсэн цэгээр нэвтэрдэг байна. Үүнд:

- Нуурын өмнө талд буюу Хатгал тосгоны нутагт оршдог нэвтрэх цэгийг гадаад, дотоодын ихэнх жуулчид ашигладаг;
- Нуурын хойд талд буюу Ханх сумын нутаг дэвсгэрт оршдог нэвтрэх цэгийг ихэнхдээ ОХУ-ын жуулчид ашигладаг.


Хөвсгөл аймгийн төв Мөрөн хотоос Хатгал тосгоны төв хүртэл хатуу хучилттай замтай. Тус зам нь дээр дурдсан “Хатгалын нэвтрэх цэг”-ээр нэвтэрсний дараа Хатгал тосгон болон Хөвсгөл нуурын зүүн талаар явсаар Ханх сумын төв хүрэх 2 үндсэн чиглэлд салаалдаг байна. Хатгал тосгоны төв рүү чиглэсэн хатуу хучилттай замаас сайжруулсан шороон зам салаалан Жанхайн даваа, Тойлогт чиглэл рүү явдаг байна. Ханх чиглэлийн зам нь ердийн шороон зам байна.

Хөвсгөл нуурын баруун тал буюу Жанхайн даваа, Тойлогт чиглэлд ХНБЦГ-ын бүсэд байрлах жуулчны баазуудын 80% орчим нь, нуурын зүүн тал буюу Ханх чиглэлд жуулчны баазуудын 20% орчим нь байрлан үйл ажиллагаа явуулдаг. [2]

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төслийн талбайн байршил


“Хатуу хучилттай автозам, авто зогсоол, явган жим, нэвтрэх цэгүүд байгуулах төсөл”-ийн таушлбай нь Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын, Хатгал тосгоны нутаг дэвсгэрт хэрэгжиж байна (Зураг 1).



Зураг- 1.Төсөл хэрэгжих байршлуудыг засаг захиргааны хуваарийн зурагт үзүүлэв

2.2 Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн уур амьсгалын нөхцөл

Төсөл хэрэгжих Алаг-Эрдэнэ сумын нутаг нь үндсэн гурван том байгалийн бүс бүслүүрийг дамнан оршино.




Зураг- 2. Төсөл хэрэгжих бүс нутгийн байгалийн бүс бүслүүрийн зураг

2.2.1 Агаарын температур ба дулааны горим

Ерөнхий төлөв

Хатгал орчмын нутаг дэвсгэр нь голын хөндий дагасан буюу уулс хоорондын хөндий ихтэй учраас сэрүүвтэр ба хоногийн дундаж агаарын температур намар дунджаар 10 дугаар сарын үеэс 0 градусаас буурч хүйтэрнэ. Хавар нэлээд хожуу 4 дүгээр сарын дунд 10 хоногоос эхлэн 0 градусыг давж дулаарч эхэлдэг ба дунджаар 179 хоног хүйтэн байдаг. УЦУОСМХ-ээс гаргасан Уур амьсгалын нормоос харахад Хатгалд жилийн 1 дүгээр сард хамгийн хүйтэн байх бөгөөд агаарын дундаж температур -23.0 градус ба хамгийн хүйтэндээ -47.7 градус, 7 дугаар сард хамгийн халуун буюу 12.5 градус ба хамгийн халуундаа 31.8 градус хүрсэн байна. Харин жилийн дундаж температурын -4.1°C байдаг байна (Хүснэгт 1).

Агаарт анхны цочир хүйтрэх дундаж хугацаа 8 дүгээр сарын 2-р арав хоногт байх ба хамгийн эрт нь 8 дугаар сарын 1-р арав хоногт ажиглагдана. Харин сүүлчийн цочир хүйтрэх дундаж хугацаа 6 дугаар сарын 3-р арав хоногт, хамгийн хожуу нь 7 дугаар сарын 2-р арав хоногт тохиолдож, цочир хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа дунджаар 47-70 орчим хоног байна [3].



Зураг- 3. Хөвсгөл аймгийн 1 ба 7 дугаар сарын дундаж агаарын температурын тархалт

Хүснэгт- 1. Хатгал станцын агаарын температурын дундаж, үнэмлэхүйн их, бага утга (°C)*

	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Дундаж	-23.0	-19.8	-11.8	-1.9	5.2	10	12.5	10.8	4.9	-2.9	-12.9	-19.8	-4.1
Үнэм/их	1.9	6.6	15.5	23.2	28.1	29.8	31.8	31.8	25.8	20.7	12.2	6.9	31.8
Үнэм/бага	-47.7	-43.8	-39.8	-28.1	-19.7	-7.6	-4.7	-5.7	-22.5	-30.6	-41.3	-43.1	-47.7
1-р 10 хоног	-22.6	-21.8	-14.9	-4.4	2.7	8.7	11.9	12.0	7.2	0.4	-9.1	-18.2	-4.0
2-р 10 хоног	-23.3	-19.4	-12.4	-1.9	5.8	10.3	13.0	10.8	4.9	-2.8	-13.8	-20.1	-4.1
3-р 10 хоног	-23.2	-18.3	-8.1	0.5	7.1	10.9	12.5	9.5	2.4	-6.3	-15.8	-21.1	-4.2

*Эх үүсвэр: УЦУОСМХүрээлэн, Уур амьсгалын норм, 2019 он.

Олон жилийн явц

Цаг уурын Хатгал станцын 1999-2019 оны 21 жилийн мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд, жилийн дундаж агаарын температурын олон жилийн дундаж нь -3.6°C байгаа нь агаарын температурын хувьд хүйтэн бүсэд хамаарагдахыг харуулна. Харин 21 жилийн агаарын температурын өөрчлөлтийн шугамын хандлагыг авч үзэхэд энэ хугацаанд Хатгалд агаарын дундаж температур (T_a) 0.9 градус, хамгийн бага температур (T_{\min}) 0.4 градус, харин хамгийн их температур (T_{\max}) 1.5 градусаар өссөн байна (Зураг 4).



Зураг- 4. Агаарын температурын олон жилийн явц

2.2.2 Хур тунадас

Ерөнхий төлөв

Цаг уурын Хатгал станцын сүүлийн 30 жилийн ажиглалтын мэдээгээр тооцоолж гаргасан уур амьсгалын нормоор жилдээ дунджаар 312.8 мм хур тунадас ордог байна. Тус нутаг нь хур тунадасны хувьд чийглэг бүсэд багтдаг (Хүснэгт 2). Жилийн хамгийн их тунадас 8 дугаар сард, хамгийн бага нь 1-2 дугаар сард ордог байна. Нийт тунадасны 84% нь зуны улиралд буюу 6-8 дугаар сард, үүний 65% нь зөвхөн 7-8 дугаар сард ордог байна. Жилд дунджаар 68 хоног бороотой, 7 хоног мөндөртэй байдаг байна. Хур тунадас аажмаар буурсаар үлдсэн 10 хувийн тунадас намрын сүүл, өвөл, хаврын улиралд цас хэлбэрээр унана. Жилд дунджаар 9 дүгээр сарын дундуур анхны цас орох ба сүүлийн цас 6 дугаар сарын дундуур ажиглагдаж, ойролцоогоор 100 хоног цасан бүрхүүлтэй байна. Цасан бүрхүүлийн дундаж зузаан 3-8 см, цасны нягт 0.17-0.23 г/см³ байна. Жилд дунджаар 26 хоногт цасан шуурга шуурдаг байна.




Зураг- 5. Хөвсгөл аймгийн жилийн нийлбэр хур тунадасны тархалт

Хүснэгт- 2. Хур тунадасны жилийн доторх өөрчлөлт

	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Нийлбэр	1.6	1.4	2	7.8	19.6	57.7	92.8	78.1	35	9	5.5	2.3	312.8
Хоногийн хам/их	8.6	9.2	5.7	24.4	41.7	210.6	198.7	129.6	94.7	36.4	20.7	9.9	210.6
1-р 10 хоног	0.7	0.6	0.5	1.8	3.6	12.8	21.2	30.3	15.4	4.5	3.1	1	95.5
2-р 10 хоног	0.4	0.5	0.8	2.6	6.6	17	31.1	26.1	10.9	2.8	1.5	0.5	100.5
3-р 10 хоног	0.6	0.4	0.7	3.4	9.4	27.9	40.5	21.7	8.7	1.7	0.9	0.8	116.8

Олон жилийн явц

Төсөл хэрэгжиж буй нутагт жилд ордог хур тунадасны дундаж хэмжээ нь олон жилийн явцад 59.9 мм-ээр нэмэгдсэн байна. Олон жилийн мэдээнээс харахад 161.9 мм-ээс 433 мм хур тунадас орж байсан байна [2].



Зураг- 6. Жилийн нийлбэр хур тунадасны олон жилийн явц

2.2.3 Салхины горим

Төсөл хэрэгжиж буй нутагт өмнөд, хойд, баруун зүгийн салхи зонхилох бөгөөд өмнөд болон хойд зүгийн салхины давтагдал жилд дунджаар 20-32 % хүрдэг байна (Зураг 8).



Зураг- 7. Салхины зүгийн давтагдал


Төсөл хэрэгжиж буй нутагт салхины дундаж хурд 2.5-3.7 м/с, хамгийн их хурд 16-25 м/с хүрдэг. Жилдээ 14 удаа хүчтэй салхи (15 м/с-ээс дээш) ажиглагддаг. Жилд дунджаар 19 хоногт шороон шуурга шуурдаг байна.



Зураг- 8. Салхины сарын дундаж болон хамгийн их хурд, м/с


2.2.4 Хөрсний температур

Төсөл хэрэгжиж буй нутагт хөрсний гадаргын температурын явц агаарын температуртай ижил хэлбэлзэх буюу 1 дүгээр сард хамгийн хүйтэн буюу дунджаар -25.3 градус, үнэмлэхүй бага температур нь -41 градус, 7 дугаар сард хамгийн халуун буюу дунджаар 18.3 градус, үнэмлэхүй их температур нь 52.9 градус байна.



Зураг- 9. Хатгал станц дахь хөрсний температурын үзүүлэлтүүд

Хатгал цаг уурын станцын 1999-2019 оны мэдээгээр хөрсний гадаргын жилийн дундаж температур -0.4 -өөс -4.2 градус байжээ. Сүүлийн 21 жилд 1999 оноос 2005 он хүртэл буурч хамгийн бага үзүүлэлтэд хүрснээ 2007 он хүртэл огцом өсөж хамгийн их утагд хүрсэн байна. Үүний дараа 2012 он хүртэл буурч, 2014, 2016 онуудад нэлээд өссөн, цаашдаа 2019 он хүртэл буурчээ. Өөрчлөлтийн хандлага нь агаарын дундаж температурын өсөлтөөс (0.9) бага эрчимтэй буюу 0.6 градус байна [2].




Зураг- 10. Хөрсний гадаргын температурын олон жилийн явц

2.2.5 Гадаргын болон газар доорх ус

2.2.5.1 Бүс нутгийн гадаргын усны чанар

Эргэн тойрон сүрлэг өндөр уулсаар хүрээлэгдсэн энэ нуурын талбай 2760 ам км, 136 км урт, 20-37 км өргөн, эргийн шугамын урт 414 км, 138-265 м гүн, 380.7000 шоо км эзэлхүүнтэй, 4920 ам км ус хураах талбайтай. Хөвсгөл нуур нь манай орны төдийгүй Төв Азийн хамгийн гүн нуурт тооцогддог. Усны нөөц нь манай орны бүх гол мөрний жилийн нийлбэр урсацаас бараг 10 дахин их ба уг нуур нь тектоник ангалд үүссэн гэдэг утгаараа олон тооны булан тохой, арал хойгтой бөгөөд энэ нь ч нуурыг улам чимж байдаг. Далайн хүйс, Модон хүйс, Хадан хүйс зэрэг томоохон арлуудаас Далайн хүйс хамгийн том нь бөгөөд усан мандлаас 126м-т өргөгдсөн, 3 км урт, 2 км өргөн, 5.8 ам км талбайтай, эргийн шугамын урт 8.5км, битүү ой модоор хучигдсан байна. Хөвсгөл орчмын нутаг нь Сибирийн их тайга болон Төв Азийн их тал нутгийн зааг дээр орших өвөрмөц тогтоцтой. Манай орны цэнгэг усны нөөцийн 90 гаруй хувийг эзлэх, том жижиг 101 гол цутгаж, ганц Эг гол гардаг онцлогтой. “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газар 2010 онд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамруулан гол мөрний урсацын дийлэнх хэсэг буюу 70 гаруй хувь нь бүрэлдэн бий болдог “Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн зааг”-ийг бүсчлэлийн кодоор кодлон дугаарласан 18 аймгийн 109 талбай, 6958 цэгийн газарзүйн солбицол, талбай тус бүрийн хилийн урт (км), талбай (км.кв), харьяалах аймаг, сумаар нь нэг бүрчлэн тогтоосон. Эдгээр мэдээллээс Хөвсгөл нуурын сав газрын мэдээллийг доорх зургаар харуулаа.



Зураг- 11. Гадаргын усны сүлжээ

Хүснэгт- 3. Хөвсгөл нуурын усны химийн шинжилгээний тодорхойлолт

Анион	1 дм ³ -д байгаа			Катион	1 дм ³ -д байгаа		
	мг/л	Мг/эquiv	Мг-эquiv%,		мг/л	Мг/эquiv	%, мг-эquiv/л
Cl	3.6	0.10	3.03	Na ⁺ +K ⁺	11.6	0.51	15.29
SO ₄ ²⁻	8.0	0.17	5.04	NH ₄ ⁺	38.1	1.90	57.48
NO ₃ ⁻	0.0	0.00	0.00	Ca ²⁺	10.9	0.90	27.23
NO ₂ ⁻	2.4	0.04	1.17	Mg ²⁺	0.0	0.00	0.0
CO ₃ ²⁻	6.0	0.20	6.05	Fe ²⁺	0.0	0.00	0.0
HCO ₃ ⁻	170.8	2.80	84.71	Fe ³⁺	0.0	0.00	0.0
Дүн	190.8	3.31	100.00	Дүн	60.6	3.31	100.00

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 165.99 мг/дм³
 Анион катионуудын нийлбэр: 251.39 мг/дм³
 Ерөнхий хатуулаг: 2.80 мг-эquiv/дм³ рН: 8.12, ЕС: 332µS/cm, TDS: 167 ppm
 Исэлдэх чанар 3.84 мг/л
 Физик шинж чанар:
 Тунгалаг: 30 см Үнэр: үгүй Тунадас: үгүй
 Өнгө: үгүй Амт: үгүй

$$\text{Усны найрлагын томъёо: } M_{0.25} = \frac{HCO_3-85}{Ca^2+57Mg^2+27Na^+K+15}$$

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөн ус байна. Шинжилгээний дүнг ГУЦЗАН-тай харьцуулахад “Цэвэр” ангилалд хамаарах ба “Усан орчны чанарын үзүүлэлт MNS 4686:1998 стандарт”-ын шаардлага хангаж байна.

Хүснэгт- 4. Хатгал тосгоны худгийн усны шинжилгээний тодорхойлолт

Анион	1 дм ³ -д байгаа			Катион	1 дм ³ -д байгаа		
	мг/л	Мг/эquiv	Мг-эquiv%,		мг/л	Мг/эquiv	%, мг-эquiv/л
Cl	10.7	0.30	8.50	Na ⁺ +K ⁺	14.2	0.62	17.50
SO ₄ ²⁻	15.0	0.31	8.86	NH ₄ ⁺	42.1	2.10	59.51
NO ₃ ⁻	0.0	0.00	0.00	Ca ²⁺	9.7	0.80	22.67
NO ₂ ⁻	1.0	0.02	0.46	Mg ²⁺	0.2	0.01	0.31
CO ₃ ²⁻	0.0	0.00	0.00	Fe ²⁺	0.0	0.00	0.00
HCO ₃ ⁻	176.9	2.90	82.18	Fe ³⁺	0.0	0.00	0.00
Дүн	203.6	3.53	100.00	Дүн	66.2	3.53	100.0

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 181.31 мг/дм³
 Анион катионуудын нийлбэр: 269.76 мг/дм³
 Ерөнхий хатуулаг: 2.90 мг-эquiv/дм³ рН: 7.89, ЕС: 332µS/cm,
 TDS: 191 ppm Исэлдэх чанар: 1.76 мг/л
 Физик шинж чанар:
 Тунгалаг: 30 см Үнэр: үгүй Тунадас: үгүй
 Өнгө: үгүй Амт: үгүй

$$\text{Усны найрлагын томъёо: } M_{0.25} = \frac{HCO_3-82}{Ca^2+60Mg^2+23Na^+K+17}$$

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, маш зөөлөн ус байна. Шинжилсэн физик, химийн бүх үзүүлэлт нь “Ундны усны MNS 900:2005 стандарт”-ын шаардлага хангаж байна.

2.2.6 Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн судалгаа

Хатгал-Жанхай-Гойлогт чиглэлийн шороон замын, Хатгал-Хүзүүвчийн шил чиглэлийн шороон зам дагуух орчны талбайн хөрсний төлөв байдлын хээрийн судалгааг 2022 оны 4,8-р саруудад 2 удаа хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: хөрсний гадаргын төлөв байдал, хөрсний үе давхаргын морфологи шинж чанар, хөрсний үржил шимийн түвшин, хөрсний хими, физик шинж чанарыг тодруулах зорилгоор байршил тус бүрээс 5-8 ширхэг дээж авч хөрсний ижил хэв шинжийг харгалзан хөрсний гадаргын бичиглэл хийсэн байна. [2] Дээж авсан цэгүүдийн байршлыг хүснэгтээр үзүүлэв (Хүснэгт 5).

Хүснэгт- 5. Хөрсний дээж авсан цэгийн байршил

Зүсэлт	Газрын нэр	Уртраг	Өргөрөг
1	Замын эхлэл	100.149	50.430
2	2-р цэг	100.114	50.462
3	Карьер-1	100.146	50.425
4	5.5 км замын дунд хэсэг	100.154	50.468
5	5.5 км замын төгсгөл	100.163	50.497
6	Карьер 2	100.114	50.475
7	Кемп-1	100.114	50.480
8	Карьер-3	100.115	50.488
10	32.5 км замын төгсгөл	100.283	50.651
11	Карьер-4	100.114	50.565
12	Кемп-2	100.102	50.545
13	Хуучин ашиглаж байсан карьер	100.109	50.507



Зураг- 12. Хөрсний дээж авсан цэгүүдийн байршил

2.2.6 Нутаг дэвсгэрийн хөрсний тархалт

Төсөл хэрэгжиж буй нутаг нь Монгол орны Хөрс Газарзүйн мужлалаар хөрс био-уур амьсгалын өндрийн бүсшилийн Хангайн их муж, Хөвсгөлийн дэд муж, Хөвсгөлийн баруун, 36-р тойрогт багтана. Төсөл хэрэгжих нутаг нь нийтдээ уулархаг дунджаар 2500 орчим метр өргөгдсөн бөгөөд хамгийн өндөр цэг 3460 метр, нам цэг нь 1500 метр байдаг. Хөвсгөл нуурын баруун, зүүн тойргийн хөрсөн бүрхэвчид Уулын нугархаг хээрийн бүлэг, Уулын цэвдэгт хар шороон хөрс, Уулын ойн ширэгт бараан хөрс, Уулын хар хүрэн хөрс, Уулын нугын ба нугат хээрийн бүлэг, Уулын нугын цэвдэгт хөрс, Уулын хүрэн хөрс, Далд глейрхэг хар шороон хөрс, Голын татмын бүлэг, Аллювийн нуга-намгийн хөрс, Аллювийн нугын хөрс, Чийгт гарлын Нугын хүрэн хөрс, Намгийн хүлэрлэг, глейт хөрс өргөн тархалттай байна. [2]

Харин замын трассын хэмжээнд Глейрхэг Харшороон, Тайгын цэвдэгт хөрс болон чулуурхаг хурдас зонхилох талбайг эзлэх бөгөөд Жанхайн давааны хойд хэсэгт ойн цоорхой, нуурын эргийн задгай хэсгүүдэд Цэвдэгт бараан, ширэгт бараан, сайргархаг Харшороон хөрс тус тус тархсан байна.

2.2.7 Ургамалан нөмрөг болон ойн бүрхэвч

Судалгаа явуулсан нутаг нь ургамал газарзүйн мужлалаар Евразийн шилмүүст ой, нуга хээрийн их муж, Алтай Соёны муж, Улаан тайга-Хорьдол Сарьдагийн, Хөвсгөл нуурын зүүн хэсгийн тойрогт (Монгол улсын Үндэсний атлас, 2009), Умард Монголын ой-ургамалжилтын мужлалаар Өмнөд өвөр байгалийн ой ургамалжлын муж, Дархадын хошуу, Дархадын тойрог, Зүүн эргийн тойрогт (Цэдэндаш, 1993), физик газарзүйн мужлалаар Алтай-Соёны уулт их муж, Хөвсгөл нуурын баруун хэсэг дэд муж, Өвөр Байгалийн уулт тайгын их муж, Эг-Сэлэнгийн уулт тайгын муж, Хөвсгөл нуурын зүүн хэсгийн дэд мужид тус тус багтана (Даш, 2000).

Тухайн нутагт ургамалжилтын хувьд уулын араар голлон тохиолдох цэвдэгт тайгын хүлэрлэг-глейрхүү хөрстэй газраар уулын шинэсэн ба хуш шинэсэн тайга, уулсын арын ширэгт тайгын гүн цэвдэгт хөрстэй газрын өвслөг ургамалт шинэсэн ой, нам ба дундаж өндөр уулсын үетэн-алаг өвст ба нугын хээр, голын татмын армаг тармаг шинэсэн ой, намгийн хүлэрлэг цэвдэгт хөрстэй татмын алаг өвс-улалжит хүлэрт намаг, намагжсан нуга, үетэн-улалжит нугын ургамалжилттай.

Төслийн талбайд шинэсэн ой, уулын нугын хээр, уулын хээр, хүлэрт намаг, намагжсан нуга, татмын нугын ургамалжилт тохиолдлоо [3].

2.2.8 Хээрийн судалгааны бичиглэл

Ургамлын бичиглэл № 1. Эгийн голын гүүрний дээд хэсэгт хойт өргөрөгийн $50^{\circ} 26'21.0^{\circ}$, зүүн уртрагийн $100^{\circ} 08'44.8^{\circ}$, д.т.д 1650 м-т голын хөндийн их талхлагдсан үетэн-ширэг улалжит хээржсэн нугын бүлгэмдэл. Өвслөг бүрхэвчийн тусгаг бүрхэц 70%, ургамлын дундаж өндөр 8 см байх ба зонхилогч ургамал нь Ширэг улалж, Түнхлэй хиаг, Нугын биелэг өвс, Их таван салаа зэрэг ургамал бүлгэмдэл үүсгэнэ

Ургамлын бичиглэл №2. Хатгалын төвөөс 11 км-т замын трассын баруун талдаа шинэсэн ойтой, зүүн талдаа том сайр дагасан тармаг шинэстэй. Хойт өргөрөгийн $50^{\circ} 31'3.8$, зүүн уртрагийн $100^{\circ} 6'588$, д.т.д 1788 м. Замаас 50 м-ийн зайд шинэсэн ойн элдэв өвс-үетэнт (ботуульт) бүлгэмдэлд бичиглэв. Сөөгөн ташингын тусгагийн бүрхэц 25%,

дундаж өндөр нь 1.5 м. Өвслөг бүрхэвчийн тусгаг бүрхэц 70%, ургамлын дундаж өндөр 36 см байх ба Зонхилогч ургамал нь Хонин Ботууль, Сибирь Биелэг өвс, Амгуны Улалж, Хулганын Гиш зэрэг ургамал бүлгэмдэл үүсгэн ургана. 10х10 м-ийн талбайд 2Ш (230), 9Ш (50) шинэстэй. Насны 2 үелэлтэй. 2Ш нь тойргийн диаметр нь 1 м, өндөр нь 17-18 м, 9Ш нь тойргийн диаметр 40 см, өндөр нь 7-8 м байлаа. Байгалийн сэргэн ургалт нь 5х5 м-ийн талбайд 6 шинэстэй, өндөр нь 1.2-1.5 м байлаа.

Ургамлын бичиглэл №3. Замын трассын Жанхайн давааны өвөрт урд талаараа шинэсэн ойтой, хойт талаараа өндөр уулын тагтай. Хойт өргөрөгийн $50^{\circ} 33'44.9^{\circ}$, зүүн уртрагийн $100^{\circ} 6'34.5^{\circ}$, д.т.д 1842 м. Жанхайн голын элдэв өвс-улалжит хүлэрт намаг. Өвслөг бүрхэвчийн тусгаг бүрхэц довон дээр 60%, хотгорт 70%, ургамлын дундаж өндөр 8 см байх ба зонхилогч ургамал нь Ильний Улалж, Ширэг улалж, Нугын Биелэг өвс, Намгийн Дүндэггарав зэрэг ургамал бүлгэмдэл үүсгэн ургаж байна. Ногоон хөвд – довонд 15%, хотгорт нь 35%-ийн бүрхэцтэй ургана. Тухайн талбайд хөрсний зүсэлт хийхэд 10-60 см-т хүлэртэй байлаа. Хүлэрт намаг нь усны эргэлтийн чухал хэсэг, усыг тогтоон барих өндөр чадавхитай, уур амьсгалыг зөөлрүүлдэг, цэвдэг хайлахаас хамгаалдаг, ихээхэн хэмжээний нүүрстөрөгчийг хурмтлуулдаг зэрэг ихээхэн ач холбогдолтой. Хүлэрт намгийн доройтол нь амьдрах орчин багасах, биологийн олон янз байдлыг алдагдуулахад хүргэнэ. Энэ голын дагуу 8 айлын 200 гаруй бод, 400 гаруй богтой. Бэлчээрийн талхлагдлаас гадна жуулчдын хөл хөдөлгөөнд ихээхэн өртсөн газар юм.

Ургамлын бичиглэл № 4. Жанхайн даваа уруудаад нуураас 90 м-ийн зайтай амралтын газрын чигт хойт өргөрөгийн $50^{\circ} 35'43.9^{\circ}$, зүүн уртрагийн $100^{\circ} 11'28.6^{\circ}$, д.т.д 1635 м-т их өөрчлөгдсөн боролзгоно бүхий элдэв өвс-ширэг улалжит нугын бүлгэмдэл. Сөөгөн ташингын тусгагийн бүрхэц 15%, дундаж өндөр нь 15-25 см. Өвслөг бүрхэвчийн тусгаг бүрхэц 50%, ургамлын дундаж өндөр 4 см байх ба зонхилогч ургамал нь Ширэг улалж, Ахарсорт Арвай, Нугын биелэг өвс, Түмэн навчинцарт Ортууз, Их таван салаа зэрэг ургамал бүлгэмдэл үүсгэнэ. Нуураас 90 м-ийн зайтай. Замын хойт талд амралтын газар байлаа. Ургамал бүлгэмдэл хүний болон техногенийн нөлөөлөөр их өөрчлөгдсөн.

Ургамлын бичиглэл №5. Хөвсгөлийн Тусгай Хамгаалалтын онгон бүсэд явган ба морин замын трассын зүүн талдаа шинэсэн ойтой. Хойт өргөрөгийн $50^{\circ} 45'03.4^{\circ}$, зүүн уртрагийн $100^{\circ} 13'40.7^{\circ}$, д.т.д 1666-м-т өргөгдсөн. Бид замаас 30 м-ийн зайд шинэсэн ойн элдэв өвс-үетэнт бүлгэмдэлд бичиглэв. Сөөгөн ташингын тусгагийн бүрхэц 7%, дундаж өндөр нь 40-60 см. Өвслөг бүрхэвчийн тусгаг бүрхэц 70%, ургамлын дундаж өндөр 19 см байх ба Зонхилогч ургамал нь Хонин Ботууль, Амгуны Улалж, Сибирь Цагаан суль, Сибирь Биелэг өвс, Монгол Улаан толгойт, Сэгсгэр Яргуйжин, Нарийн навчит Хөвөнт зэрэг ургамал бүлгэмдэл үүсгэн ургана. 1Ш (230), 9Ш (50) шинэстэй. Насны 2 үелэлтэй. 1Ш нь тойргийн диаметр нь 80 см, өндөр нь 17-18 м, 9Ш нь тойргийн диаметр 40 см, өндөр нь 9-10 м байлаа [3].

2.2.9 Амьтны аймгийн төлөв байдал

Төслийн талбай нь Монгол орны амьтны аймгийн мужлалаар Хөвсгөл орчмын тойрогт хамаарна (Банников,1954). Хөвсгөл нуур-Эгийн голын сав газарт 37 зүйл хөхтөн амьтан байрших боломжтойгоос 9.5 хувь нь Монгол Улсын Амьтны тухай хуульд зааснаар “нэн

ховор”, 7.9 хувь нь Засгийн газрын тогтоолын дагуу “ховор” амьтнаар бүртгэгджээ. Цэнгэг уст Хөвсгөл нуурт 9 зүйл, түүний цутгал гол, горхинд нийт 15 зүйл загас байдгаас хадран, зэвэг, гутаарь, омуль, алгана, улаан нүдэн зэрэг зургаан зүйл нь агнуурын ач холбогдолтой юм. Нуурын гүнд 15 овогт багтах 200 шахам зүйлийн ёроолын амьтад байх бөгөөд ёроолын амьтад нь загасны гол тэжээл болдог байна. Нуурын цутгал голуудад хийсэн судалгаагаар 57 төрөлд хамаарах усны сээр нуруугүйтэн. Мөн 246 хүртэлх шувууд суурин болон нүүдлийн статустай байдаг бөгөөд цагаан сүүлт бүргэд, явлаг сар, хуруут хун зэрэг долоон зүйл нэн ховор шувуу, Засгийн газрын тогтоолоор батлагдсан есөн зүйл ховор шувуу, CITES-ийн II хавсралтад бүртгэгдсэн 41 зүйл нэн ховор, ховор шувуу нутагладаг байна [2].

2.2.10 Нийгэм-эдийн засгийн төлөв байдал

Хатгал тосгон

Хатгал тосгон 91144 га эдэлбэр газартай, баруун талаараа Алаг-эрдэнэ, зүүн талаараа Чандмань-өндөр, хойд талаараа Ринчинлхүмбэ сумтай хиллэдэг, 877 өрх, 3000 хүн амтай, 27646 толгой малтай, 666 хүүхэдтэй, 77 ажиллагсадтай 12 жилийн 150 хүүхдийн дотуур байртай, бүсийн ахлах сургууль, 25 ажиллагсадтай, 15 ортой сум дундын эмнэлэгтэй, 150 хүүхэдтэй, 23 ажиллагсадтай 4 бүлэгтэй хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Газар хөдлөлтийг бүртгэх станц, Цаг уур, нуур судлалын өртөө, Хөвсгөл улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Цагдаагийн тасаг, Захирагчийн ажлын алба 10 төсөвт байгууллага үйл ажиллагаа эрхэлдэг. Мөн Усан замын газар, Хатгал нисэх буудал, мал эмнэлэг, шуудан, холбооны салбар, Мобиком, Жи-мобайлын салбарууд, ХААН, Хадгаламж банкны тооцооны төв, Нуурын зам хоршоо, төр, төсөв үйл ажиллагаа явуулж буй 27 байгууллага, аж ахуйн нэгжид 271 хүн ажилладаг мөн малчдын 3, гар урчуудын 8 бүлэг, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх иргэдийн нөхөрлөл 9, ШТС 4, байнгын ажиллагаатай дэлгүүр 23, зоогийн газар 3, цайны газар 4, кафе 2, талхны цех 3, сүү цагаан идээ боловсруулах цех 1, загас боловсруулах цех 3, гурилан бүтээгдэхүүн хийх цех 1, автомашин болон дугуй засварын газар 5, үсчин, гоо сайхны газар 1, нуур орчимд 34 жуулчны бааз, 38 гэр буудал, улирлын чанартай ажилладаг дэлгүүр 10, хог дахин ангилах, баглах 1 цэг үйл ажиллагаа явуулдаг ба гадаадын 10000 орчим жуулчид, дотоодын 40000 гаруй аялагчид зорчдог. Эдийн засаг нь мал аж ахуй, аялал жуулчлал, жижиг худалдаа үйлчилгээний орлогоос бүрддэг.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

“Хатуу хучилттай автозам, авто зогсоол, явган жим, нэвтрэх цэгүүд байгуулах төсөл”-ийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, газар дээр нь ажилласан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн магадлан жагсаах арга, матрицын аргаар тодорхойлсон болно. Энэ үнэлгээг доорх алхмуудаар гүйцэтгэв. Үүнд:

- ✚ Байгаль орчны үнэлгээний өмнөх үе шатуудад тодорхойлсон төслийн байгаль орчин, нийгмийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийн цар хүрээ, эрчим, хугацаа, шинж чанарыг нарийвчлан тодорхойлж, тоон ба чанарын шинжилгээ хийх;
- ✚ Болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний (зохих аргачлалын дагуу хийгдсэн) мэдээлэлд буулган судалж, сөрөг нөлөөллийн тархалт, үр дагаврыг үнэлэх;
- ✚ Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд төсөл хэрэгжих болон төслийн нөлөөлөлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдал, бохирдол, доройтлын түвшнийг тогтоох нэмэлт судалгаа, ажиглалт, хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэх зэрэг орно.

Тухайн төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээг хийхдээ “Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга” (Checklist)-ыг хэрэглэв. Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм.

Болзошгүй нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны өөрчлөлт, нийгэм-эдийн засаг, бусад гэсэн 5 үндсэн бүлэгт багцлан хувааж, магадлан жагсаах аргаар судлав. Нөлөөллийг “сөрөг”=(х), “**эерэг**”=(+), “нөлөөлөлгүй”=(0) гэсэн 3 бүлэглэлээр үнэлж, эрчимжилтийг: “**бага зэрэг**”, “**дунд зэрэг**”, “**хүчтэй**” гэсэн 3 зэргээр тогтоож, хэлбэр, хугацаа, чиглэлээр нь үнэлсэн болно. Төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах аргаар гүйцэтгэн дараах хүснэгтэд үзүүлэв (Хүснэгт 6).

Хүснэгт- 6. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй	Бага зэрэг	дунд зэрэг	Хүчтэй
1. Байгалийн экосистемийн өөрчлөлт											
Газрын доорх усны чанарт өөрчлөлт гарах		х	х			х		х	х		
Ургамлын бүлгэмдэл, бүтцэд өөрчлөлт орох, талхлагдах			х		х			х	х		
Хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэлд орох, дарагдах			х		х			х	х		
Геологийн тогтцын өөрчлөлт	0										

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Будаж нөлөөлөх	Буцалтгүй	Бага зэрэг	дунд зэрэг	Хүчтэй
Ойр орчимд нутагладаг ан амьтдын амьдрах орон зай өөрчлөгдөх		x		x				x	x		
Уур амьсгалын бичил өөрчлөлт		x	x	x			x		x		
2. Байгалийн нөөц, ашиглалт											
Газрын гадаргын нөөц баялаг		x	x				x	x		x	
Газрын доорх усны нөөц багасах		x	x				x			x	
Бэлчээр	0										
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
Гадаргын усны бохирдол		x		x						x	
Агаар бохирдох	0										
Хөрс бохирдох (шатах тослох материал, хог хаягдал хадгал)		x			x			x		x	
Ургамлан бүрхэвч бохирдох (шатах тослох материал, хог хаягдал)		x			x			x		x	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор											
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	0										
Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	0										
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	0										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	0										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	0										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал											
Орон нутгийн орлого нэмэгдэх	+			+					+		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+			+					+		
Ажлын байр нэмэгдэх	+			+					+		
Төслийн хэрэгцээг дагаад орон нутгийн үйлчилгээний байгууллагын эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+					+		
Нийт (сөрөг/эрэг)	0/4	8	6	3/4	4	3	1	7	5/4	5	0

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх шууд сөрөг нөлөөлөл байхгүй ба эерэг нөлөөлөл 4 байна. Шууд бус нөлөөлөл 8 байна. Нийт сөрөг нөлөөллийн 5 нь бага эрчимтэй, 5 нь дунд эрчимтэй байна. Мөн төслийн зүгээс байгаль орчинд үзүүлж болзошгүй хүчтэй нөлөөлөлд байхгүй байна. Төслийн үйл ажиллагаанаас тухайн хэрэгжиж буй орчныхоо байгалийн нөхцөлд ерөнхийдөө шууд бус, дунд зэргийн болзошгүй сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Хатуу хучилттай автозам, авто зогсоол, явган жим, нэвтрэх цэгүүд байгуулах төсөл”-ийн 2023 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖС-ын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

Дэд бүтцийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг бэлтгэл, барьж байгуулах болон ашиглалтын үе шатны батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн эхний улиралд багтаан боловсруулж батлуулна (А/618-журмын 2.15 дахь заалт).

Дэд бүтцийн төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах явцад үүсэх эвдрэлийг нөхөн сэргээх арга хэмжээг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгана (А/618-журмын 2.17 дахь заалт).

Тухайн төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага баталснаар төслийн тухайн жилийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх үүснэ (А/618-журмын 3.1 дахь заалт).

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ (А/618-журмын 4.1 дахь заалт).

